БАТЛАВ : МОНГОЛЫН ШУУГЧДИЙН ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 31-НИЙ ӨДРИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭВ.

## МОНГОЛЫН ШҮҮГЧДИЙН ХОЛБООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хийж гүйцэтгэх ажлууд | Зорилго | Хугацаа | Хариуцах эзэн | Хамтран ажиллах байгууллага, баг, гишүүд | Санхүүжилт |
|---|---|---|---|---|---|---|
| **Нэг.Дотоод зохион байгуулалтын чиглэлээр** | | | | | | |
| 1.1 | Удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдааныг товлох, бэлтгэл ажлыг хангах, гаргасан тогтоолыг албажуулж, гишүүдэд мэдээлэх | Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах, гишүүн шүүгчдэд мэдээлэл хүргэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх | Тухай бүр | Ажлын алба | Тэргүүн,<br>Удирдах зөвлөлийн гишүүд | Холбооны төсөв |
| 1.2 | Холбооны вэбсайт болон пэйж хуудсанд тухай бүр мэдээллийг оруулах, шүүгчийн талаарх албан ёсны мэдээллийг гол эх сурвалж болгох, мэдээллийг тэнцвэржүүлэх, Салбар хороодын гишүүдээс холбооны сайтад оруулах мэдээ, мэдээллийг тогтмолжуулах, | Холбооны сайтыг идэвхжүүлэх тогтмол мэдээллээр хангах, шүүхийн үйл ажиллагааг мэдээлэх, шүүгчийн ажлыг иргэд олон нийтэд үнэн зөвөөр таниулан сурталчлах,<br>Салбар хороод, хувь гишүүдийг холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах | Жилдээ | УЗГ,<br>З.Ганзориг, Холбооны ажлын алба,<br>ГХДХ Ц.Цогт | Тэргүүн,<br>УЗГ,<br>Ажлын алба,<br>Салбар хороод,<br>Гадаад харилцааны дэд хороо | Холбооны төсөв |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Шүүгчийн холбооны сайтыг шинэчлэх, ажлын даалгавар боловсруулах<br><br>Холбооны байршил, холбоо барих, харилцах, шинэчлэлийг тогтмол хийж, нийт гишүүдэд и-мэйлээр мэдээлэл хүргэх техникийн боломжийг бүрдүүлэх<br><br>Цахим хуудас болон и-мэйл хаягт Англи хэлээр харилцах, мэдээлэл авах хаяг, этгээдийг тодорхой болгох, | | | | | |
| 1.3 | Холбооны нийт гишүүдийн Их хурлыг товлон хуралдуулах, хэлэлцэх асуудлыг бэлтгэх<br><br>Шинэчлэгдсэн дүрмийн хүрээнд УЗ-ийн гишүүний сонгуулийг зохион байгуулах | | Эхний 3 улиралд | УЗГ, Н.Одонтуул, Ц.Эрдэнэчимэг | Тэргүүн, Ажлын алба | Холбооны төсөв |
| 1.4 | Холбооны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, төслийг, бэлдэж, Их хурлаар хэлэлцүүлэх /татвар/ | | Эхний 3 улиралд | УЗГ,<br><br>Г.Ганбаатар<br><br>Ц.Мөнхтулга<br><br>Л.Эрдэнэбат | Тэргүүн, ахлагч- Г.Ганбаатар, Ц.Мөнхтулга, Эрдэнэбат, Ажлын алба | Холбооны төсөв |

**Хоёр. Холбооны дүрмийн 3.1.2-т заасан чиглэлээр**

Шүүгчдийн мэдлэг, боловсрол, шүүн таслах ажиллагааны ур чадварыг дээшлүүлэх, ёс зүйн хэм хэмжээг сахих чадварыг хэвшүүлэх, гишүүд мэдлэг, туршлагаа солилцоход дэмжлэг үзүүлэх зорилгоор сургалт, зөвлөгөөн, зохион байгуулах, гарын авлага, ном, сэтгүүл хэвлэн гаргах

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.1 | "Шударга ёсны хэмжүүр" сэтгүүлд орох мэдээ, нийтлэлийг цуглуулах, эмхэтгэх, редакторлах, цахим хэлбэрээр бэлтгэж холбооны сайтад байршуулах | Холбооны гишүүдийн эрдмийн болон чөлөөт уран бүтээлийг таниулах, сэтгүүлийг олон нийтэд хүргэх, Холбооны үйл ажиллагааг сурталчлах, Ахмад болон туршлагатай шүүгч нараас бусад шүүгч нар суралцах боломжийг нээх | Жилд 2 удаа<br>хагас, бүтэн жилээр | УЗ гишүүн Г.Ганбаатар<br>Ажлын алба | Сэтгүүлийн эрхлэгч, Сэтгүүлийн зөвлөл,<br>Эх бэлтгэгч | Холбооны төсөв |
| 2.2 | ШЕЗ-ийн "Шүүх эрх мэдэл" эмхэтгэлд "Монголын Шүүгчдийн Холбооны үйл явдлын хураангуй" нэрээр холбооны үйл ажиллагааг жилд 2 удаа нийтлэх | Холбооны үйл ажиллагааг таниулан сурталчлах, нийт шүүгчдэд хүргэх | Жилд 2 удаа | УЗГ Г.Ганбаатар Ажлын алба | Ажлын алба, ШЕЗ-ийн Шүүхийн захиргааны сургалт судалгааны төв | |
| 2.3 | Гишүүн шүүгчдийн гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, Фулбрайтын англи хэлний хөтөлбөрийг үргэлжлүүлэх<br>Канадын тэтгэвэрт гарсан шүүгч нартай хамтарсан ярианы цахим сургалт, хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг нээх | Шүүгчдийн гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх | Эхний хагас жил | ГХДХ Ц.Цогт<br>Ажлын алба | Тэргүүн<br>ШССМА<br>Шихихутуг ИС<br>АНУ-ын элчин сайдын яам,<br>Канадын төсөл | |
| 2.4 | Judicial Wellbeing буюу Шүүгчийн ажил мэргэжлийн зохист хэвшлийн талаар сургалт зохион байгуулах | Шүүгчдийн санал хүсэлтэд тулгуурласан байх<br>Олон улсын тэргүүлэх мэргэжилтнийг урьж эхний сургалт явуулах /шүүгч-багш/, мөн нийт шүүгч нарт зориулсан хичээл, гарын авлага боловсруулах | Тухай бүр | ГХДХ Ц.Цогт<br>УДШ-ийн Салбар хороо Ажлын алба | Тэргүүн,<br>ШССМА,<br>УДШТГ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.5 | Шихихутуг Их сургуультай хамтран ажиллах санамж бичиг, гэрээний дагуух үйл ажиллагааг үргэлжлүүлэх | • Менторшип хөтөлбөрийг үргэлжлүүлэх<br>• Багшлах эрх олгох сургалт | | УЗГ, Ц.Эрдэнэчимэг<br>Ажлын алба | Тэргүүн | |
| 2.6 | Эрх зүйн онолын болоод салбарын сүүлийн үеийн шинэлэг ойлголт, тодорхой судлаачийн судалгааны ажлын талаар хэлэлцүүлэг, яриаг өрнүүлэх | | Жилд 2-оос доошгүй удаа | Тэргүүн,<br>УЗГ<br>З.Ганзориг | ШССМА,<br>Судлаач,<br>Шүүгч нар | |
| **Гурав. Холбооны дүрмийн 3.1.3-д заасан чиглэлээр**<br>Шүүгчийн бие даасан, хараат бус байдлыг хангах асуудлаар эрдэм шинжилгээний бага хурал, сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, хэвлэл мэдээллийн хурал зохион байгуулах | | | | | | |
| 3.1 | Үндсэн хуулийн хүрээлэнгээс эхлэн гаргасан "Үндсэн хууль манай сургуульд" хөтөлбөрийг ашиглан шүүгч нараар иргэд, олон нийтэд ардчилал, хүний эрхийн талаар яриа, таниулгыг өргөн хүрээнд зохион байгуулах | Тодорхой хөтөлбөр, жишиг гарын авлага боловсруулж, салбар хороо, гишүүн бүрийг идэвхтэй оролцуулахыг зорих | Жилдээ | Тэргүүн<br>УЗГ<br>Ц.Мөнхтулга | Салбар хороод, бүх шатны сургууль, иргэд, хуулийн этгээдүүд | |
| **Дөрөв. Холбооны дүрмийн 3.1.4-д заасан чиглэлээр**<br>Гадаадын ижил зорилго бүхий байгууллагатай харилцаа тогтоох, хамтран ажиллах, шүүгчдийн сургалт, айлчлалыг харилцан зохион байгуулах, түүнчлэн шүүгчид дээрх байдлаар харилцаа тогтоох, харилцан мэдээлэл туршлага солилцох, хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх | | | | | | |
| 4.1 | 1.ОУ-ын шүүгчдийн холбооны их хуралд оролцох<br>2.ОУШХолбооны Ази, Номхон далай, хойд Америкийн бүсэд | Олон улс дахь хамтын ажиллагаагаа идэвхжүүлж, өргөжүүлэх<br>1.ОУШХ-ны уулзалт-3 квот | 2, 4 дүгээр улирал | ГХДХ Ц.Цогт<br>Ажлын алба | Тэргүүн<br>УЗ гишүүд | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хамаардаг газар зүйн хувьд ойролцоо бөгөөд суралцах боломжтой улсуудын Шүүгчдийн холбоо тус бүртэй 2 талт хамтын ажиллагаа эхлүүлэх хүсэлт хүргүүлэх, улмаар зөвшөөрсөн холбоотой хамтын ажиллагаа эхлүүлэх | 2. AUSTRALIA (The Australian Section of the International Association of Judges)<br>2. CANADA (Canadian Superior Courts Judges Association)<br>6. KAZAKHSTAN (Union of Judges of the Republic of Kazakhstan)<br>10. NEW ZEALAND (Judges Association of New Zealand)<br>11. PHILIPPINES (The Metropolitan and City Court Judges Association of the Philippines – METCJAP)<br>13. REP. OF CHINA (TAIWAN) (Judges Association of the Republic of China)<br>14. USA (Federal Judges Association) | | | | |
| 4.2 | Олон улсын шүүгчдийн холбооны гишүүнчлэлийн үр дүнг холбооны гишүүдэд хүртээмжтэй болгох | -Жил бүр зохион байгуулагддаг хурлын үеэр явагддаг Судалгааны тайлан, түүний үр дүнг Салбар хороодод хүргүүлэх<br>-Уг судалгаанаас суралцаж, өөрсдийн үйл ажиллагаанд хэвшүүлэх боломжтой сайн туршлагыг хэлэлцэж, нэвтрүүлэхийг дэмжих<br>-бүс нутгийн уулзалтыг хүлээн авах замаар сургалт зохион байгуулах, хамтын ажиллагааг эрчимжүүлэх талаар судлах | Жилдээ | ГХДХ Ц.Цогт<br>Ажлын алба | Тэргүүн<br>УЗГ | |
| 4.3 | Шүүгчийг гадаад улсад мэргэжлийн болон эрдэм шинжилгээний ажил хийх, суралцах /сургалтын болон бусад тэтгэлэг | БНСУ зэрэг улсын жишээнээс суралцах | Жилдээ | ГХДХ<br>Ц.Цогт<br>Ажлын алба | Дээд боловсрол төлбөргүй Герман, Австри зэрэг улсуудад явах бол шүүгчийн цалинг суралцах хугацаанд өгдөг байхад болно, харин АНУ зэрэг улсад бол тэтгэлэг | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | дэмжлэгтэйгээр/ боломжийг нээсэн албан ёсны бодлогын баримт бичиг боловсруулж, холбогдох хууль, журамд тусгуулах | | | | дэмжлэг хэрэгтэй учир төсөвт эхний ээлжид 2-3 шүүгчийн сургалтын болон амьжиргааны төсөв суулгах замаар эхлүүлэх | |
| 4.4 | Жой Спурлок сантай хэрэгжүүлж буй хамтын ажиллагааг үргэлжлүүлэх | | Жилдээ | ГХДХ<br>Ц.Цогт<br>Ажлын алба | УЗГ Ц.Оч | |
| **Тав. Салбар хороод руу чиглэсэн ажил** | | | | | | |
| 5.1 | Шүүхийн цахимжилттай холбоотой шүүгч нарт чиглэсэн сургалт зохион байгуулах<br>*/Цахимжилтай холбоотой олон улсын туршлагыг шүүгч нартаа таниулах, цахимаар хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой нийтлэг арга, дэгийн талаар зөвлөмж бусад баримт бичиг гаргах* | Шүүгч нарыг цахимжилтад бэлтгэх | | Тэргүүн<br>УЗГ<br>Ц.Мөнхтулга,<br>З.Ганзориг | ШССМА<br>ШЕЗ,<br>Шүүгч<br>Н.Баярмаа<br>Ц.Цогт | |
| 5.2 | Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон Салбар хороод, гишүүдтэй уулзалт зохион байгуулах, урамшуулах асуудлыг тодорхой болгож, дүрэмд оруулах | Холбооны дүрэмд заасны дагуу явуулж буй үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах | | УЗГ<br>Г.Ганбаатар | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Зургаа. Холбооны дүрмийн 3.1.5-д заасан чиглэлээр**<br><br>Гишүүдийнхээ үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр таниулах, энэ чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцаа тогтоох, хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх | | | | | | |
| 6.1 | Ярьж буй хууль нэвтрүүлгийг үргэлжлүүлэх | Үргэлжлүүлэх эсэхийг УЗ шийдэх Үргэлжлүүлэх тохиолдолд - нэвтрүүлгийн бодлогыг -шүүгч, гишүүдэд чиглэсэн агуулгатай болгох уу эсхүл Олон нийтэд чиглэсэн ингэхдээ -шүүх, шүүгчийн ажил мэргэжил, түүний онцлог, ёс зүй, хараат бус байдлыг таниулсан чиглэлд хөгжүүлэх үү гэдгийг шийдэх | | | УЗГ Г.Ганбаатар | |
| **Долоо. Холбооны дүрмийн 3.1.7-д заасан чиглэлээр Шүүгчдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах ажлыг хуулийн дагуу зохион байгуулах, шаардлагатай бол гишүүдийн талаарх мэдээллийг цаг тухайд нь судалж, тухайн гишүүний хүсэлтийг үндэслэн хариу мэдэгдэх** | | | | | | |
| 7.1 | Шүүгчийн хүсэлтээр сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч, төлөөлөгч оролцуулахад туслалцаа үзүүлэх, шаардлагатай судалгаа, баримтуудыг гаргаж өгөх байдлаар дэм өгөх, сэтгэл зүйн болоод бусад байдлаар дэмжих | Шүүгчийн хараат бус байдал алдагдах, зөрчигдөх нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлж, нэгэнт үүссэн нөхцөл байдлыг хамгаалах зорилгоор судалгаа, саналд тулгуурлан холбогдох байгууллагад /ШЕЗ болон бусад/ хандах, уламжлах зэрэг үр дүнтэй арга хэмжээ авсан байх,<br>Ёс зүйн зөвлөх хороотой хамтрах | Тухай бүр | УЗГ Н.Одонтуул,<br><br>Ц.Оч | ШЕЗ,<br><br>Ёс зүйн зөвлөлдөх хороо | |
| **Найм. Холбооны дүрмийн 3.1.8-д заасан чиглэлээр**<br><br>Гишүүддээ сэтгэл санааны болон эрүүл мэндийн, эд материалын туслалцаа, дэмжлэг үзүүлэх | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8.1 | 1.Шүүгчийн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудлыг анхаарч, эмнэлгийн багц үзлэг шинжилгээнд хамруулах<br><br>2.Гадаад улсад эрүүл мэндийн үзлэгт оруулах ажлыг зохион байгуулах | Шүүгчдийг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулах | | УЗГ Ц.Оч<br><br>Ажлын алба | Салбар хороод<br><br>Эмнэлгүүд | Шүүгч нарын өөрсдийн зардлаар |
| 8.2 | Шүүгчдийн амь нас, эрүүл мэндийн даатгалын гэрээ байгуулах ажлын хэсэгт санал хүргүүлэх, | ШЕЗ-өөс даатгалын компанитай байгуулсан гэрээний нөхцөлийг анхаарч, шүүгчийн эрх зүйн байдал дордохоор байвал мэдсэн дариу ШЕЗ-д энэ талаар албан бичиг хүргүүлэх, санал солилцох, хүсэлтээ уламжлах | 4 дүгээр улирал | УЗГ Н.Одонтуул, Ажлын хэсэг | ШЕЗ<br><br>Иргэний хэргийн шүүгч нартай хамтран төсөл боловсруулах | |
| 8.3 | Холбооны гишүүн-шүүгч нарт тусламж, дэмжлэг үзүүлэх журамын 2.1-д заасны дагуу | | тухай бүр | Шүүгчдийн холбооны Ажлын алба | Салбар хороодын тэргүүн нар | Холбооны төсөв |
| 8.4 | МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар өндөр насны тэтгэвэрт гарч буй ахмад шүүгчдэд холбооны дүрэмд заасны дагуу хүндэтгэл үзүүлэх<br><br>/холбооны дүрэмд тусгах/ | Тус тусын шүүх дээр -Хүндэтгэлийн хуралдаан-хийх аргачлал боловсруулж, салбар хороотой хамтран зохион байгуулж хэвшүүлэх | Жилдээ | УЗГ Г.Ганбаатар | Салбар хороод | |
| **Ес. Холбооны дүрмийн 3.1.9-д заасан чиглэлээр**<br><br>Хууль, дүрэмд заасан бөгөөд Төрийн бус байгууллагад зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагааны хэлбэр | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 9.1 | Холбооны үйл ажиллагаатай холбоотой зарим журам батлах, /холбооны дүрмээр зохицуулах асуудлыг дүрэмд оруулах/ | **Журмууд:**<br>1. "Салбар хороодыг шагнах урамшуулах журам" Ц.Мөнхтулга<br>2. "Гишүүний татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх журам" Ц.Оч<br>3. "Нийт гишүүдийн хурлыг онлайнаар хийх журам" З.Ганзориг<br>4. "Гишүүдийн нэгдсэн бүртгэлийн журам" Н.Одонтуул<br>5. "Шүүгчдийн холбооны УЗ-ийн сонгуульд нэр дэвшүүлэх, сонгууль явуулах журам" Эрдэнэбат<br>6. Холбооны гишүүний нэгдсэн бүртгэлийн болон гишүүний татвар хураах, хөнгөлөх, чөлөөлөх журам батлах - Дүрмийн өөрчлөлтийн тухай журам | | УЗГ<br>Г.Ганбаатар | | |

Монголын шүүгчдийн холбооны Ажлын алба